



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Газар ивээл ТӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2025/009/НА-СТА-ТӨА

Цахим хуудас: www.audit.mn
Улаанбаатар хот
2025 он

Санхүү-нийцлийн аудитын газрын захирал,
тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: Б.Долгорсүрэн
Утас: 261885 Цахим хаяг: dolgorsurenb@audit.gov.mn
Ахлах аудитор: П.Амарсанаа
Утас: 261628 Цахим хаяг: amarsanaap@audit.gov.mn
Б энд С аудит ХХК-ийн захирал: Д.Заяажаргал
Утас: 99050268 Цахим хаяг: bcauditllc@gmail.com
Аудитор: Б.Пүрэвсүрэн
Утас: 99075081 Цахим хаяг: bcauditllc@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

0005.03.17 № 07/1047
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Газар ивээл ТӨААТҮГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн бодлого, тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг бүх материаллаг талаар нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт (АОУС), түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2023 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/255 дугаар тушаалаар 861.6 сая төгрөгийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг баталж, тайланд онд гутлын тоног төхөөрөмж худалдан авах зардлыг 300.0 сая төгрөгөөр нэмж тодотгосон байна.

Нээлттэй тендер шалгаруулалтаар 285.0 сая төгрөгийн гутал үйлдвэрлэх тоног төхөөрөмж, шууд гэрээ байгуулах аргаар 650.0 сая төгрөгийн гутлын болон сүлжмэл хувцасны түүхий эд материалыг худалдан авсан байна.

Аудитын гол асуудал

Тайлант онд Газар ивээл ТӨААТҮГ алдагдалтай ажилласан боловч Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газраас 501.7 сая төгрөгийн гутлын машин болон тээврийн хэрэгслийг хүлээн авч, Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт заасны дагуу үнэ төлбөргүй хүлээн авсан орлогоор бүртгэж, 331.6 сая төгрөгийн татварын дараах цэвэр ашигтай ажилласнаар тайлагнасан байна.

Бусад асуудал

Тус үйлдвэрийн газарт тайлант онд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газраас 216.7 сая төгрөгийн өртөгтэй Киа Карнивал маркийн автомашин шилжин ирж орлогод бүртгэсэн бөгөөд уг машинтай холбоотой бичиг баримт нууцын зэрэгтэй шалтгаанаар аудитын байгууллагад ирүүлээгүй болно.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, СТОУС-ын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АУОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдөр

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2023 оны 12 дугаар сарын 31	2024 оны 12 дугаар сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	-	-
1101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	3,150,527.45	42,630,856.85
1102	Авлага	156,333,015.95	8,405,000.00
1104	Бусад авлага	4,625,080.80	
1106	Бараа материал	265,828,396.60	127,467,553.32
1111	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	429,937,020.80	178,503,410.17
12	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ		
1201	Үндсэн хөрөнгө	152,995,315.24	621,847,852.50
1202	Биет бус хөрөнгө	28,981.55	260,000.02
1210	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	153,024,296.79	622,107,852.52
13	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	582,961,317.59	800,611,262.69
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		-
21	ӨР ТӨЛБӨР		
21101	Дансын өглөг	48,597,310.00	705,439.33
21103	Татварын өр	74,836,116.44	7,537,858.31
21108	Урьдчилж орсон орлого		1,260,000.00
21113	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	123,433,426.44	9,503,297.64
212	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		
22	ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	123,433,426.44	9,503,297.64
2301	Өмч: - төрийн	209,570,029.00	209,570,029.00
2309	Хуримтлагдсан ашиг	249,957,862.15	581,537,936.05
23091	Тайлант үеийн ашиг	-	331,580,073.90
23092	Өмнөх үеийн ашиг	249,957,862.15	249,957,862.15
2311	ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	459,527,891.15	791,107,965.05
24	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	582,961,317.59	800,611,262.69

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдөр

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2023 оны 12 дугаар сарын 31	2024 оны 12 дугаар сарын 31
1	БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО /цэвэр/	1,165,054,450.88	1,232,452,093.11
2	БОРЛУУЛАЛТЫН ӨРТӨГ	890,823,650.76	992,641,031.26
3	НИЙТ АШИГ /АЛДАГДАЛ/	274,230,800.12	239,811,061.85
5	Хүүгийн орлого	598,582.43	176,935.48
8	Бусад орлого	80,084,308.37	41,716,395.80
8.1	ОРЛОГЫН ДҮН	80,682,890.80	41,893,331.28
10	Ерөнхий ба удирдлагын зардал	211,926,244.34	299,876,136.83
11	Борлуулалт, маркетингийн зардал		1,829,833.79
12.1	ЗАРДЛЫН ДҮН	211,926,244.34	301,705,970.62
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз/гарз	-	- 0.39
17	Бусад ашиг /алдагдал/	(135,000,000.00)	351,599,345.31
17.1	ОЛЗ, ГАРЗЫН ДҮН	(135,000,000.00)	351,599,344.92
18	ТАТВАР ТӨЛӨХИЙН ӨМНӨХ АШИГ/АЛДАГДАЛ	7,987,446.58	331,597,767.43
19	Орлогын татварын зардал	14,619,435.98	17,693.53
20	ТАТВАРЫН ДАРААХ АШИГ/АЛДАГДАЛ	(6,631,989.40)	331,580,073.90
22	ТАЙЛАНТ ҮЕИЙН ЦЭВЭР АШИГ/АЛДАГДАЛ	(6,631,989.40)	331,580,073.90
24	ОРЛОГЫН НИЙТ ДҮН	(6,631,989.40)	331,580,073.90

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдөр

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмч	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2023 оны 01-р сарын 01-ний үлдэгдэл	209,570,029.00		256,589,851.55	466,159,880.55
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
3	Залруулсан үлдэгдэл				
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)			(6,631,989.40)	(6,631,989.40)
5	Өмчид гарсан өөрчлөлт				
6	Зарласан ногдол ашиг				
7	2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	209,570,029.00		249,957,862.15	459,527,891.15
8	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				-
9	Залруулсан үлдэгдэл	209,570,029.00		249,957,862.15	459,527,891.15
10	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)			331,580,073.90	331,580,073.90
11	Өмчид гарсан өөрчлөлт				
12	Зарласан ногдол ашиг				
13	2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	209,570,029.00		581,537,936.05	791,107,965.05

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдөр

/төгрөгөөр/

Мөр	Үзүүлэлт	2023 оны 12 дугаар сарын 31	2024 оны 12 дугаар сарын 31
1	ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1.1	МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (+)	1,226,580,293.28	1,540,699,980.83
111	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	1,141,316,880.00	1,508,125,411.65
116	Бусад мөнгөн орлого	85,263,413.28	32,574,569.18
1.2	МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН (-)	1,251,835,518.12	1,351,584,086.91
121	Ажиллагчдад төлсөн	293,305,084.91	509,286,966.26
122	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	3,740,228.02	5,510,886.14
123	Бараа материал худалдан авахад төлсөн	835,016,913.54	602,266,558.90
124	Ашиглалтын зардалд төлсөн	5,253,949.34	2,801,999.52
125	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	16,044,600.00	14,055,000.00
127	Татварын байгууллагад төлсөн	30,392,484.36	158,708,436.09
129	Бусад мөнгөн зарлага	68,082,257.95	58,954,240.00
1.3	ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	(25,255,224.84)	189,115,893.92
2	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
2.1	МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (+)	12,321,173.71	14,416,723.63
215	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	11,722,591.28	14,239,788.15
216	Хүлээн авсан хүүний орлого	598,582.43	176,935.48
2.2	МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН (-)	3,805,900.00	14,052,288.15
221	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	1,930,900.00	-
225	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа олгосон	1,875,000.00	14,052,288.15
2.3	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН		
3	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
3.1	МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (+)		
3.2	МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН (-)	135,000,000.00	150,000,000.00
3.2.5	Бусад	135,000,000.00	150,000,000.00
3.3	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	(135,000,000.00)	(150,000,000.00)
4	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(151,739,951.13)	39,480,329.40
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	154,890,478.58	3,150,527.45
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	3,150,527.45	42,630,856.85

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдөр

/мянган төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны		Зөрүү	Хувь
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Нийт орлого	1,251,700.0	1,253,344.8	(1,644.8)	100.1
1.1	Борлуулалтын цэвэр орлого	1,251,700.0	1,234,293.0	17,407.0	98.6
1.2	а. Борлуулалтын орлого-гутал, арьсан эдлэл	832,500.0	917,034.0	(84,534.0)	110.2
1.3	б.Борлуулалтын орлого-сүлжмэл	419,200.0	317,259.0	101,941.0	75.7
1.4	Бусад орлого	-	19,051.8	(19,051.8)	100.0
2	Нийт зардал	1,085,684.1	1,436,154.6	(350,470.4)	132.3
2.1	ББӨ	684,780.0	992,641.0	(307,861.0)	145.0
	Удирдлагын зардал	400,904.1	443,513.5	(42,609.4)	110.6
2.2	Цалин хөлс	167,861.9	186,564.9	(18,703.0)	111.1
2.3	ЭМД	3,357.2	3,690.5	(333.2)	109.9
2.4	Алба хаагчийн шагнал урамшуулал, буцалтгүй тусламж дэмжлэг	37,224.6	17,900.0	19,324.6	48.1
2.5	Автомашин татвар, даатгал	190.0	93.5	96.5	49.2
2.6	Бичиг хэрэг	2,064.0	6,738.6	(4,674.6)	326.5
2.7	Санхүүгийн программын үйлчилгээний төлбөр	560.0	504.1	55.9	90.0
2.8	Бусад зардал	4,680.0	45,801.4	(41,121.4)	978.7
2.9	Шатахууны зардал	5,231.2	3,790.8	1,440.4	72.5
2.1	Шуудан холбоо, интернэт	2,760.0	2,547.3	212.7	92.3
2.11	Хүнс	960.0	-	960.0	-
2.12	Урсгал засвар	1,481.0	191.7	1,289.3	12.9
2.13	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ	1,000.0	6,677.2	(5,677.2)	667.7
2.14	Цэвэрлэгээний материал	-	39.2	(39.2)	100.0
2.15	Цахилгаан	605.5	-	605.5	-
2.16	Элэгдлийн зардал	15,500.0	11,293.6	4,206.4	72.9
2.17	Сэлбэг хэрэгсэл	841.0	-	841.0	-
2.18	Дээд байгууллагад төвлөрүүлэх орлого	150,000.0	150,000.0	-	100.0
2.19	Тавилга, эд хогшил	1,500.0	-	1,500.0	-
2.2	Машин тоног төхөөрөмж	4,550.0	5,504.5	(954.5)	121.0
2.21	Хөдөлмөр хамгаалал	-	346.4	(346.4)	100.0
2.22	Цэвэр бохир ус	58.9	-	-	-
2.23	Борлуулалт маркетингийн зардал	-	1,829.8	-	100.0
2.24	Дулаан	478.8	-	-	-
3	Татварын өмнөх ашиг /алдагдал/	166,015.9	(182,809.8)	348,825.6	(110.1)
	Орлогын татварын зардал	16,600.0	-	16,600.0	-
4	Цэвэр ашиг, алдагдал	149,415.9	(182,809.8)	332,225.6	(122.3)
5	Хөрөнгө оруулалтын зардал	6,050.0	5,500.0		

3. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

3.1. Аудитаар нийт 2.5 сая төгрөгийн алдаа илэрснийг аудитын явцад залрууллаа.

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Борлуулалтын тээврийн зардлыг бүтээгдэхүүний өртөгт шингээж бичилт хийсэн	1	1.8			1	1.8	1	1.8				
Шатахууныг худалдан авалт хийсэн дүнгээр биш мөнгө төлсөн дүнгээр орлогод бүртгэсэн	1	0.7			1	0.7	1	0.7				
Дүн	2	2.5			2	2.5	2	2.5				

3.2. Аудитаар нийт 8.7 сая төгрөгийн зөрчил илэрснээс 0.3 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 8.4 сая төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, 2 зөвлөмж өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллага д шилжүүлсэн асуудал	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Хүүхэд асрах чөлөөтэй байгаа ажиглалтанд цолны нэмэгдэл 0.3 сая төгрөгийг давхардуулан олгосон.	1	0.3	1	0.3								
Үйлдвэрлэлд тавьж олгосон 1.2 сая төгрөгийн туслах материалыг дуусаагүй үйлдвэрлэл-ҮНЗ дансанд бүртгэж, бүтээгдэхүүний өртөгт шингээлгүй ерөнхий удирдлагын зардлаар бүртгэсэн.	1	1.2			1	1.2						

Бүртгэлийн алдаа гаргаж 0.2 сая төгрөгийн хий өглөг үүсгэсэн.	1	0.2					1	0.2			
Нэхэмжлэх үүсгэсэн 7.0 сая төгрөгийн худалдан авалтыг төлбөрийн цахим баримтаар баталгаажуулаагүй, татвар ноогдох орлогоос хасаж тооцсон байна.	1	7.0					1	7.0			
Дүн	4	8.7	1	0.3	1	1.2	2	7.2			

3.3. АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитаар 166.0 сая төгрөгийн 2 албан шаардлага хүргүүлсэн.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/сая төгрөгөөр/					
			Үүнээс				Зөвлөмж	
	Төлбөрийн акт	Албан шаардлага	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<i>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил</i>								
Шилэн дансны тайланд орлогын 74.6 сая төгрөгийн 2 гүйлгээ, зарлагын 76.5 сая төгрөгийн 7 гүйлгээг ил тод тайлагнаж мэдээлээгүй байна. Өмнөх оны аудитаар шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээллийг хугацаанд нь мэдээлэх, зөрчлийг дахин гаргахгүй байх зөвлөмж өгсөн хэрэгжээгүй	1	16.0			1	16.0		
Дүн	1	16.0			1	16.0		
<i>Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил</i>								
Урьд онд 6.6 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байхад 150.0 сая төгрөгийн ногдол ашиг төвлөрүүлэхээр ШШГЕГ-аас төлөвлөгөө өгч, 2024 онд төвлөрүүлсэн байна.	1	150.0			1	150.0		
Нийт дүн	2	166.0			2	166.0		